

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/263/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1 . ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/113

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант 206,795.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

019020196

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,652,506.19	69,240,204.73
31	МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	36,316,029.41	39,178,515.53
312	Банканд байгаа бэлэн мөнгө	36,316,029.41	39,178,515.53
3121	Төгрөг	36,316,029.41	39,178,515.53
31	Төрийн сангийн харилцах	36,316,029.41	39,178,515.53
35	БАРАА МАТЕРИАЛ	29,336,476.78	30,061,689.20
351	Түүхий эд материал	3,506,291.84	3,031,909.06
35110	Тусгай зориулалттай материал	3,506,291.84	3,031,909.06
354	Хангамжийн материал	25,830,184.94	27,029,780.14
35410	Бичиг хэргийн материал	144,850.00	90,850.00
35420	Аж ахуйн материал	19,491,890.03	25,855,280.13
35440	Түлш шатах тослох материал	1,517,194.01	190,260.01
35470	Хүнсний материал	4,676,250.00	893,390.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	594,937,617.68	783,130,938.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	594,937,617.68	783,130,938.28
392	Биет хөрөнгө	584,601,617.68	772,794,938.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	511,580,634.73	668,634,281.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,313,945.32)	(13,098,948.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	800,000.00	800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(399,999.96)	(399,999.96)
39205	Машин тоног төхөөрөмж	63,820,162.40	71,266,162.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,656,548.20)	(25,154,223.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,783,028.00	24,898,028.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,976,542.97)	(4,515,670.57)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,996,000.00	51,995,680.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(3,599,199.96)
39217	Номын фонд	1,968,829.00	1,968,829.00
393	Биет бус хөрөнгө	10,336,000.00	10,336,000.00
39301	Программ хангамж	133,000.00	133,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(133,000.00)	(133,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,336,000.00	10,336,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	660,590,123.87	852,371,143.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,349,288.45	3,403,020.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,349,288.45	3,403,020.00
413	Өглөг	1,349,288.45	3,403,020.00
4132	Бараа ажил үйлчилгээний зардлын өглөг	1,349,288.45	3,403,020.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	659,240,835.42	848,968,123.01
51	Засгийн газрын хувь оролцоо	659,240,835.42	848,968,123.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,472,213.64	90,472,213.64
51101	Өмч:-төрийн	90,472,213.64	90,472,213.64
512	Хуримтлагдсан үр дүн	334,390,802.38	524,118,089.97
51210	Өмнөх үеийн үр дүн	334,390,802.38	334,390,802.38
51220	Тайлант үеийн үр дүн		189,727,287.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,377,819.40	234,377,819.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	660,590,123.87	852,371,143.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,052,154,809.74	660,807,927.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	629,504,209.74	206,795,327.00
120	Нийтлэг татварын бус орлого	629,504,209.74	206,795,327.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	145,157,536.40	206,795,327.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	462,358,671.16	
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	21,988,002.18	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72,776,700.00	32,322,800.00
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэх		421,689,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		421,689,800
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,573,200.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	23,573,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,203,500.00	32,322,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,203,500.00	32,322,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	387,470,590.14	471,080,639.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,470,590.14	471,080,639.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	362,524,197.55	464,676,231.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,563,503.83	326,278,872.92
210101	Үндсэн цалин	192,527,102.48	186,421,406.38
210102	Нэмэгдэл	40,113,807.50	126,855,759.54
210104	Урамшуулал	19,922,593.85	13,001,707.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,445,024.17	38,901,764.96
210201	Тэтгэврийн даатгал	21,532,631.55	26,386,664.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,526,943.62	3,169,804.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,026,282.61	2,737,199.83
210204	Ажилгүйдлийн даатгал	483,498.24	577,073.04
210205	Эрүүл мэндийн даатгал	4,875,668.15	6,031,023.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,455,692.85	33,968,536.86
210301	Гэрэл, цахилгааны зардал	4,600,248.45	12,884,982.86
210302	Түлш, халаалтын зардал	18,385,194.40	21,083,554.00
210303	Цэвэр, бохир усны зардал	470,250.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	927,931.00	95,200.00
210401	Бичиг хэргийн материал	298,000.00	95,200.00
210402	Тээвэр, шатахууны зардал	510,201.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	119,730.00	
2105	Норматив зардал	32,728,000.00	32,861,426.00
210502	Хоол, хүнс	32,728,000.00	32,861,426.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	2,235,180.00
210604	Урсгал засвар	500,000.00	2,235,180.00

Төв аймгийн Сэргэлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	503,420.00	681,019.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		59,800.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	503,420.00	621,219.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,400,625.70	29,654,231.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,718,791.00	9,233,225.58
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,325,929.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,355,905.70	20,421,006.40
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,946,392.59	6,404,407.69
	Бусад урсгал шилжүүлэг	23,469,700.00	6,389,479.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,563,500.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс олгосон дэмжлэг, тусламж	9,906,200.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,389,479.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох татаас, санхүүжилт	1,476,692.59	14,928.69
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,476,692.59	14,928.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	664,684,219.60	189,727,287.59
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,003,234.18	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,003,234.18	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,003,234.18)	
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	662,680,985.42	189,727,287.59

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,472,213.64	234,377,819.40	159,496,640.30	484,346,673.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,472,213.64	234,377,819.40	(328,290,183.04)	(3,440,150.00)
Тайлант үеийн үр дүн			662,680,985.42	662,680,985.42
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,472,213.64	234,377,819.40	334,390,802.38	659,240,835.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	90,472,213.64	234,377,819.40	334,390,802.38	659,240,835.42
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			189,727,287.59	189,727,287.59
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,472,213.64	234,377,819.40	524,118,089.97	848,968,123.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	422,650,600.00	454,012,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	422,650,600.00	454,012,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		421,689,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		421,689,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,873,900.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,573,200.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	23,573,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,203,500.00	32,322,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага	49,203,500.00	32,322,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	386,334,570.59	447,065,113.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,334,570.59	447,065,113.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,388,178.00	440,228,706.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,601,347.78	326,278,872.92
210101	Үндсэн цалин	195,564,946.43	186,421,406.38
210102	Нэмэгдэл	40,113,807.50	126,855,759.54
210104	Урамшуулал	19,922,593.85	13,001,707.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,407,180.22	38,901,764.96
210201	Тэтгэврийн даатгал	21,525,872.85	26,386,664.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,531,355.05	3,169,804.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,029,284.16	2,737,199.83
210204	Ажилгүйдлийн даатгал	479,398.01	577,073.04
210205	Эрүүл мэндийн даатгал	4,841,270.15	6,031,023.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,686,500.00	30,587,871.31
210301	Гэрэл, цахилгаан	4,600,248.45	12,884,982.86
210302	Түлш, халаалт	17,616,001.55	17,702,888.45
210303	Цэвэр, бохир усны зардал	470,250.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	
	Бичиг хэрэг	103,500.00	
2105	Норматив зардал	37,404,250.00	29,078,566.00
210502	Хоол, хүнс	37,404,250.00	29,078,566.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	636,019.00
210806	Мэдээлэл, технологийн зардал	814,000.00	636,019.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,871,400.00	13,245,612.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,641,400.00	11,968,312.00

Төв аймгийн Сэргэлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,230,000.00	1,277,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,946,392.59	6,836,407.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,469,700.00	6,821,479.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,563,500.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	9,906,200.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,821,479.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,476,692.59	14,928.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,476,692.59	14,928.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,316,029.41	6,947,486.12
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		4,085,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		4,085,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		4,085,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		4,085,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(4,085,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	36,316,029.41	2,862,486.12
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		36,316,029.41
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,316,029.41	39,178,515.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		36,316,029.41	(36,316,029.41)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	490,328,700.00	451,150,113.88	39,178,586.12	92.0%
УРСГАЛ ЗАРДАЛ	490,328,700.00	451,150,113.88	39,178,586.12	92.0%
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,461,600.00	444,313,706.19	39,147,893.81	91.9%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344,319,800.00	326,278,872.92	18,040,927.08	94.8%
Үндсэн цалин	216,659,300.00	186,421,406.38	30,237,893.62	86.0%
Нэмэгдэл	115,277,700.00	126,855,759.54	(11,578,059.54)	110.0%
Урамшуулал	12,382,800.00	13,001,707.00	(618,907.00)	105.0%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	44,976,300.00	38,901,764.96	6,074,535.04	86.5%
Тэтгэврийн даатгал	30,584,400.00	26,386,664.00	4,197,736.00	86.3%
Тэтгэмжийн даатгал	3,598,100.00	3,169,804.41	428,295.59	88.1%
ҮОМШӨ-ний даатгал	2,878,000.00	2,737,199.83	140,800.17	95.1%
Ажилгүйдлийн даатгал	719,700.00	577,073.04	142,626.96	80.2%
Эрүүл мэндийн даатгал	7,196,100.00	6,031,023.68	1,165,076.32	83.8%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,822,800.00	30,807,871.31	14,928.69	100.0%
Гэрэл, цахилгаан	7,736,200.00	13,104,982.86	(5,368,782.86)	169.4%
Түлш, халаалт	22,886,600.00	17,702,888.45	5,183,711.55	77.4%
Цэвэр, бохир ус	200,000.00		200,000.00	
Норматив зардал	44,020,500.00	29,078,566.00	14,941,934.00	66.1%
Хоол, хүнс	44,020,500.00	29,078,566.00	14,941,934.00	66.1%
Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00		100.0%
Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00		100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	704,300.00	636,019.00	68,281.00	90.3%
Мэдээлэл технологийн зардал	704,300.00	636,019.00	68,281.00	90.3%
Бараа үйлчилгээний бусад зардал	17,117,900.00	17,110,612.00	7,288.00	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	15,004,900.00	14,997,612.00	7,288.00	100.0%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,113,000.00	2,113,000.00	0	100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,867,100.00	6,836,407.69	30,692.31	99.6%
Бусад урсгал шилжүүлэг	6,867,100.00	6,821,479.00	45,621.00	99.3%
Нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,867,100.00	6,821,479.00	45,621.00	99.3%
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		14,928.69	(14,928.69)	

Төв аймгийн Сэргэлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төсвийн шилжүүлэг		14,928.69	(14,928.69)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	490,328,700.00	454,012,600.00	36,316,100.00	92.6%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	458,005,900.00	421,689,800.00	36,316,100.00	92.1%
Улсын төсвөөс санхүүжих	458,005,900.00	421,689,800.00	36,316,100.00	92.1%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,322,800.00	32,322,800.00		100.0%
Орон нутгийн төсвөөс	32,322,800.00	32,322,800.00		100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		36,316,029.41	(36,316,029.41)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		39,178,515.53	(39,178,515.53)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	22	22		100.0%
Удирдах ажилтан	1	1		100.0%
Гүйцэтгэх ажилтан	10	10		100.0%
Үйлчлэх ажилтан	11	11		100.0%

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,322,800.00	32,322,800.00		100.0%
УРСГАЛ ЗАРДАЛ	32,322,800.00	32,322,800.00		100.0%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,322,800.00	32,307,871.31	14,928.69	100.0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,822,800.00	30,807,871.31	14,928.69	94.0%
Гэрэл, цахилгаан	7,736,200.00	13,104,982.86	(5,368,782.86)	169.4%
Түлш, халаалт	22,886,600.00	17,702,888.45	5,183,711.55	77.4%
Цэвэр, бохир ус	200,000.00		200,000.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00		100.0%
Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00		100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		14,928.69	(14,928.69)	
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		14,928.69	(14,928.69)	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		14,928.69	(14,928.69)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,322,800.00	32,322,800.00		100.0%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,322,800.00	32,322,800.00		100.0%
Орон нутгийн төсвөөс	32,322,800.00	32,322,800.00		100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00		94.9%
Удирдах ажилтан	1.00	1.00		100.0%
Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00		100.0%
Үйлчлэх ажилтан	11.00	11.00		100.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйл ажиллагааг танхимын болон зайны сургалтын хэлбэрийг хослуулан, үе шаттайгаар чанартай зохион байгуулж, эцэг эх асран хамгаалагчийн дэмжлэг оролцоог бүхий л хэлбэрээр дэмжин, суралцахууд тулгарч буй бэрхшээлийг арилгах замаар хүүхэд бүрийг ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН болгон төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь анхан шатны боловсрол олгох юм.

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилт, 56 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас нийт 92.5%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 191,781.0 мянган төгрөгөөр буюу 29.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	36,316.0	39,178.5	2,862.5
Бараа материал	29,336.5	30,061.7	725.2
Үндсэн хөрөнгө	594,937.1	783,130.9	188,193.3
Нийт хөрөнгө	660,590.1	852,371.1	191,781.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	660,590.1	852,371.1	191,781.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	660,590.1	852,371.1	191,781.0

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,862.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 725.2 мянган төгрөгөөр өссөн нь эцэг эхчүүдээс хүлээн авсан хүүхдийн ариун цэвэр, бичиг хэргийн материалыг бүртгэж эхэлсэн, мөн 2,266.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж 157,053,6 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 7446.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 10,115.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 33,999.7 мянган төгрөгөөр нэмэгдэж энэ нь тайлант онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 156,833.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 7,446.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,250.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авсан ба барилга байгууламжийн дансанд 220.0 мянган төгрөг, тавилга эд хогшилд 3,865.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдаж авсан нь үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 852,371.1 мянган төгрөг болж 191,781.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 421,689.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 32,322.8 мянган төгрөг,

нийт 454,012.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 7,901.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 71,815.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 490,328.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 451,150.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 39,178.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 451,150.1 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71801- Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,056.5	1,050.0	6.5	99.3%
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	34,513.1	28,078.6	6,434.5	81.3%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,719.2	2,719.2	0	100%
1.4	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,056.5	1,055.7	0,8	99.9%
1.5	Нүүдлийн бүлэгт хамруулах	9,954.0	9,564.1	389.9	96.08%
1.6	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	209,140.3	214,533.5	(5,393.2)	102%
1.7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	163,250.2	161,826.3	1,423.9	99.1%
1.8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	32,322.8	32,322.8		100%
	Дүн	454,012.6	451,150.2	2,862.4	99.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн нь Сэргэлэн сумын цэцэрлэг нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 130,661.85 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Хүүхдийн хоол хүнс 44,020.5 мянган төгрөг, 22,886.6 мянган төгрөгийн түлш халаалтын зардлыг нээлттэй тендер шалгаруулахаар, 17,822.2 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардал, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, төлбөр хураамжийн зардлуудыг шууд худалдан авалтаар, гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 73,536.5 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн буурсан цэцэрлэгийн хүүхдийн тоо багассантай холбоотой 893.3 мянган төгрөгийн хоол, хүнсийг зарцуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 387,470.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 5,812.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,359.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан түлш хаалтын зардлыг 5,306.7 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Судалгааны үр дүн, нөхцөл байдлын талаар бичих

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн бүртгэлд байгаа үндсэн хөрөнгө болон цалин хөлс, урамшуулал, байр ашиглалт, эрүүл мэндийг дэмжих, хүүхдийн хоол, багшийн мэргэжил дээшлүүлэх, цахим хэрэглээ, хэрэгжиж буй төсөл арга хэмжээтэй холбоотой 8 судалгааг ирүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс, 146 мэдээллийг хугацаанд нь, 54,210.6 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, өмнөх оны албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол,” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж, 3 албан шаардлага, 2 төлбөрийн акт өгөгдсөнийг 63% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 12/09 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	959.1	2	959.1	100%
Албан шаардлага	4	405,508.0	4	251,298.0	62%
Зөвлөмж	3	10,866.4	3	10,866.4	100%
Нийт дүн	9	417,333.5	9	263,123.5	63%

/мянган төгрөгөөр/

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Сэргэлэн сумын Хүүхдийн цэцэрлэгт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 869,476.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг хөрөнгийн тодруулга тайлангаас 206,795.3 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл 662,680.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 5,032.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

5.1 Албан шаардлага

Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ,

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ”; Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэж заасныг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Газрын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газар эзэмших эрхийн гэрчилгээнд Төв аймгийн Төв аймаг Сэргэлэн сумын 1-р баг, Баянбүрд нэгж талбарын дугаар 0000219762 м.кв газрыг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж газрыг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж тайлагнах

2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилга байгууламжид 1,629.8 төгрөгийн элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.35 дугаар зүйлд "Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох заавар журмын дагуу тайлант хугацаанд элэгдлийг тооцоолж хэвших

3. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд нийлүүлэгч байгууллагад 3,403.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж өр төлбөр үүсгэхгүй ажиллах

4. Хандив тусламжийн орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд эцэг, эхчүүд болон иргэд, байгууллагаас авсан хандив тусламжийн үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа "Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан"-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1-д "Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль /цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч

гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг "Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан"-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах харилцааг энэхүү дүрмээр зохицуулна" гэж заасантай, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох заавар журмын дагуу тайлант хугацаанд хандив тусламжийн үндсэн хөрөнгө, бараа материалыг сан бүрдүүлэн орлогод бүртгэж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг хөрөнгийн тодруулга зөрүүтэй	1	206,795.3			1	206,795.3	1	206,795.3				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй	1	662,680.9			1	662,680.9	1	662,680.9				
Дүн	2	869,476.2			2	869,476.2	2	869,476.2				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрыг санхүүгийн тайланд бүртгээгүй	1	-					1	-				
Барилга, байгууламжийн	1	1,629.8					1	1,629.8				

Төв аймгийн Сэргэлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

элэгдлийг тооцоолоогүй.												
Өр төлбөр үүсгэсэн	1	3,403.0					1	3,403.0				
Үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө, бараа материалыг орлогодож сан байгуулах	1	-					1	-				
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж тайлагнаагүй	1	-							1	-		
Дүн	5	5,032.8					4	5,032.8				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдээлбэл зохих 10 мэдээг хугацаа хоцроон байршуулсан.	10	54,210.6			10	54,210.6		
Дүн	10	54,210.6			10	54,210.6		



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 105-17225502-ТӨА-2024/263/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд 54,210,600.00 төгрөгийн 10 мэдээг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.2-д мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх; 4.1.3-д тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Сэргэлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Б.Бямбадорж, нягтлан бодогч Ж.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040379



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 98-17225502-ТӨА-2024/263/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан нягтлан бодогч Ж.Энхжаргалд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Сэргэлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Б.Бямбадорж, нягтлан бодогч Ж.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

